

БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА:

/Ц.ТУЛГА/

АРХИТЕКТУР ТӨЛӨВЛӨЛТИЙН ДААЛГАВАР

1119281793
ТОО489 2117401
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ

2020 оны 6 сарын 3 өдөр

Дугаар: ГБМЗХ 2020/22-046

Улаанбаатар хот

1	Газар олголтын захирамжийн дугаар, олгогдсон газрын байршил, хэмжээ ГБМЗХ2020/22 хурлын шийдвэр	НЗД 2020 оны 5 сарын 13 өдөр-ний А/640-тоот газар эзэмшүүлэх шийдвэртэй, 18641312541565, 18641312599596, 18641312588573, 18641312558589, 18641312539585, 18641312602576, 18641312522581, 18641312578592, 18641312561568, 18641312578571, 18641312621600 дугаар нэгж талбартай, Чингэлтэй дүүргийн 8-р хорооны нутаг дэвсгэрт, Зүүн Тасганы-10 гудамны нийт 11 нэгж талбарт хашаанд-д Нийслэлийн Боловсролын газарт сургуулийн зориулалтаар олгосон 2270.0 кв.м газрыг үндэслэв. /НГЗБА-аас өгсөн 47 нэгж талбарыг чөлөөлөх санал/
2	Барилга байгууламжийн нэр, зориулалт, хүчин чадал	: Нийслэлийн Боловсролын газар, Дунд сургуулийн барилга
3	Барилгын хэмжээ /Төлөвлөлтийн талбайгаар/	3153.30 кв.метр төлөвлөлтийн талбайд нормын дагуу хүчин чадлыг тооцон төлөвлөх
4	Барилгын төрөл, давхрын тоо	Давтан хэрэглэх тухайлсан , 3 давхар хүртэл /-зоорьтой /
5	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, ерөнхий төлөвлөгөөний бүсчлэл	Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Дэнжийн мянга орчмын ХЕТ
6	Эдэлбэр газрын:	4124.2 кв.м /газар чөлөөлөх/ үүнээс 2270.0 кв.м /захирамжийн/,
	- Барилгажих талбай (70 хувиас ихгүй)	3153.0кв.м
	- Ногоон байгууламж, гадна тохижилт	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-ийн дагуу /ХБТХууль 12.6.3/
	- Авто зогсоол	БНБД-ийн дагуу төлөвлөх /ХБТХууль 12.6.3/
- Бусад /гараж/	БНБД-ийн дагуу төлөвлөх	
	- Түр хашаа барих төлөвлөлтийн /урт, өндөр	Эдэлбэр газарт багтаан, хашааны өндөр 3 метр, хамгаалалтын торны өндөр 2 метр, "Нийслэлийн нутаг дэвсгэрт хашаа, хайс барих, ашиглах буулгах журам"-ыг мөрдөх;
7	Талбайн ерөнхий төлөвлөгөө, тохижилтонд тавигдах шаардлага	БНБД 30-01-04-ийн Зөвлөмжийн 13 дугаар хавсралтын дагуу тооцон эдэлбэр газрыг нэмэгдүүлэх. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04 болон Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03 -ийн ногоон байгууламж төлөвлөх, зам талбайд гэрэлтүүлэг хийх, гадна тохижилтын зургийг иж бүрэн боловсруулах. Гадна талбайд биеийн тамирын талбай, жагсаалын талбай, амрах талбайг тооцон төлөвлөх.
8	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан, нэгдсэн байдлаар төлөвлөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан арга хэмжээг MNS 6056:2009, 6055:2009 стандартын дагуу төлөвлөх. Барилгын нүүр талыг зориулалтын дагуу өнгө төрхийг шийдвэрлэн, авто замын орц гарц, явган замыг уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөж, барилгын зураг төслийг хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргаж боловсруулна. Галын аюулгүй байдлын норм дүрмийг баримтлан төлөвлөлтөд тусгах. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04 болон Олон нийт иргэний барилга БНБД 31-03-03, "Ерөнхий боловсролын сургуулийн барилгын төлөвлөлт" БД 11-113-11-ийг чандлан мөрдөх.
9	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	Сургуулийн орчны эрүүл ахуй, аюулгүй байдлын зай хэмжээг хангуулан барилгын хойд хэсэгт дуу чимээ тусгаарлах хана, амьд хашаа /мод бут/ зэргийг төлөвлөх. Авто замаас аюулгүй байхаар тооцон сургуулийн барилгыг байршуулах, явган зам талбай ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт


		хийх, төвлөрсөн инженерийн хамгамжийн шугамд холбогдох. Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21-02-02 баримтлан төлөвлөх. Тухайн орчны барилга байгууламж, авто зам болон явган зам талбай, ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт хийх, Барилгын талбайн зохион байгуулалтын зургийг хавсаргах. Эдэлбэр газрын хэмжээг нэмэгдүүлэн газрын захирамж гаргуулах ажлыг холбогдох байгууллагатай зөвшилцөн шийдвэрлүүлснээр загвар зураг баталгаажих болно.
10	Талбайн өндөржилтөнд тавигдах шаардлага	Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх
11	Инженерийн шугам сүлжээнд тавигдах шаардлага	Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас, норм дүрэм стандартыг баримтлан төлөвлөх. Барилгын ажил эхлүүлэхээс өмнө дулаан, цэвэр усны хос шугамыг шилжүүлэх зөвшөөрлийг холбогдох байгууллагаас авах /гадна шугам сүлжээний зураг төслийг мэргэжлийн байгууллагаар хянуулах/
12	Инженерийн бэлтгэл арга хэмжээ (үерийн хамгаалалт, далан, суваг, шуудуу, зайлуулах шугам сүлжээ)	Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорхи болон дээрхи шугам сүлжээг тодруулсаны үндсэн дээр зураг төслийг боловсруулах
13	Барилгажилтын улаан шугам	Магадлал хийлгэсэн ажлын зургийн дагуу барилгын 0 тэнхлэг тавиулж, барилгын ажлыг эхлүүлэх
14	Захиалагчийн нэр, хаяг, утас	Нийслэлийн Боловсролын газар

Анхааруулга:

1. Барилга барих явцад хүрээлэн буй орчны байгалийн тогтоц, өмнө хийгдсэн тохижилт, зам талбай, ногоон байгууламжийг хамгаалах ба хэрэв хөндвөл нөхөн сэргээх.
2. Өндөр барилгын бүсчлэлд талбайн хэмжээнд микросейсмикийн үнэлгээ гаргуулах, цогцолбор барилгын инженерийн хангамж, шугам сүлжээ, дэд бүтцийн техникийн нэгдсэн шийдлийг шийдвэрлэх.
3. Хуучин барилга, байгууламжийг зайлшгүй буулгах, зөөх, засварлах, шаардлагатай болэнэ тухай эрх бүхий байгууллагын албан ёсны техникийн дүгнэлт (акт), шийдвэрийг архитектур төлөвлөлтийн даалгаварт хавсаргах.
4. Барилга байгууламжийн зураг төслийг боловсруулахдаа АТД-т заасан нэр, зориулалт, барилгын давхрын тоо, хэмжээнээс хэтрүүлсэн тохиолдолд эскиз зураг батлагдахгүй болно.

Хянасан: Хот дахин хөгжүүлэх хэлтсийн дарга /М.МЭНДСАЙХАН/


Боловсруулсан: Хот дахин хөгжүүлэх хэлтсийн архитектор /Г.Лхамноржин/



ТӨЛӨВЛӨЛТИЙН ТАЛБАЙН СХЕМ ЗУРАГ

(дугаар: ГБМЗХ 2020/22-046 архитектур төлөвлөлтийн даалгаврын хавсралт)

Байршил	Эзэмшигч	Зориулалт
Чингэлтэй дүүргийн 8-р хороо	Нийслэлийн Боловсролын газар	сургуулийн



Масштаб 1: 1,000
ТАНИХ ТЭМДЭГ

- Одоо байгаа барилга
- ХХХ хэмжээ
- Газрын хэмжээ
- Цэвэр усны шугам
- Бохирын шугам
- Дулааны шугам
- Холбооны шугам
- Үерийн шугам

Байршлын дугаар: 598515

Тусгаа: WGS 1984 UTM Zone 48N
ТОДОРХОЙЛОЛТ

1	Төлөвлөж буй байршил
2	Чөлөөлөх газар
3	Одоо байгаа барилга
4	Буудах барилгууд
5	ХЕТ-ний авто зам, талбай

ОЛГОСОН ТАЛБАЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эдэлбэр газар (м2)	4124.18 м2
Төлөвлөлтийн талбай (м2)	3153.30 м2

(Архитектур төлөвлөлтийн даалгаврын хамт хүчинтэй.)

ЭРГЭЛТИЙН ЦЭГҮҮДИЙН СОЛБИЦОЛ

№	X	Y	тал=урт(м)
1	641551.137	5310444.011	1-2=55.43
2	641496.836	5310432.862	2-3=1.99
3	641496.435	5310434.813	3-4=12.57
4	641484.268	5310431.661	4-5=22.69
5	641478.107	5310453.497	5-6=16.54
6	641461.834	5310450.545	6-7=15.06
7	641458.462	5310465.221	7-8=109.81
8	641566.545	5310484.636	8-9=12.26
9	641568.901	5310472.601	9-10=23.17
10	641546.161	5310468.148	10-1=24.64



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР
Хот дахин хөгжүүлэх хэлтэс

Нийслэлийн Засаг захиргааны 2-р байр 1308 тоот
Утас: 11-315319, website: <http://uda.ub.gov.mn>

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА

Б.МӨНХБАТ

**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН 8 ДУГААР ХОРОО 640 СУУДАЛТАЙ СУРГУУЛИЙН БАРИЛГА
БАРИХ ЗУРАГ, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

2020 оны 06-р сарын 03 -ны өдөр

Дугаар 2020/57

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05-р сарын 13-ны өдрийн А/640 дугаар захирамж. Хот байгуулалт, хөгжлийн газрын 2020.06.03-ны өдрийн ГБМЗХ 2020/22-046 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар
2	Барилга байгууламжийн байршил	Улаанбаатар хот. Чингэлтэй дүүрэг 8-р хороо
3	Зориулалт, хүчин чадал	- 640 суудалтай
4	Барилгын үндсэн бүтээц, материал	- Төмөр бетон каркас - Гадна фасад өнгөлгөөний тоосго
5	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр	<ul style="list-style-type: none">- Олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбох.- Техникийн нөхцөл олгогдоогүй тохиолдолд өөрийн эх үүсвэрээр инженерийн шугам, сүлжээний зураг төсөв боловсруулан холбогдох байгууллагуудтай зөвшилцөн, батлуулах.- Төслийн талбайд шугам сүлжээ илэрвэл зөөх шилжүүлэх техникийн нөхцөл гаргуулах бөгөөд тухайн шугам сүлжээний зөөх шилжүүлэх ажлын зураг болон зардал, авто зам, зам талбайн нөхөн сэргээлтийн зардлыг төсөвт тусгаж мэргэжлийн байгууллагатай зөвшилцөн баталгаажуулах
6	Зураг төслийн бүрдэл	<p><u>Баримт бичгийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах- Инженер геологийн дүгнэлт- Инженерийн шугам сүлжээний тодруулга- Онцгой байдлын дүгнэлт- Мэргэжлийн хяналтын дүгнэлт- Магадлалын нэгтгэсэн дүгнэлт /Хавсралт дүгнэлтийн хамт/ <p><u>Ажлын зургийн иж бүрдэл:</u></p> <ul style="list-style-type: none">- Нүүр хуудас /батлагдах/- ЕТ- Ерөнхий төлөвлөгөө, өндөржилт- БА- Барилга архитектур- ТХ-Технологийн зураглал- ББ- Барилга бүтээц / Бүтээцийн тооцооны хамт/- ХС- Халаалт, салхивч- ЦБУ- Усан хангамж, ариутгах татуурга- ЦА- Цахилгаан хангамж- ХД- Холбоо дохиолол- ГД- Гадна дулаан- УАТГ- Гадна усан хангамж ариутгах татуурга- ГЦ- Гадна цахилгаан- ГХ- Гадна холбоо- Барилгын төсөв / Тооцооны ESTIMATOR-PRO программ/ <p><u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u></p> <ul style="list-style-type: none">- Тохижилтын элементүүдийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба ерөнхий харагдах байдлыг 3D буюу 3 хэмжээст зураглалаар гүйцэтгэх;

		- Зураг төслийг хот байгуулалтын мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага. а. Хот байгуулалтын мэдээллийн сангийн стандартыг мөрдөх. б. Хийгдэж буй төслийн дэвсгэр зургийн WGS-84, UTM буюу солбицлын нэгдсэн тогтолцоонд хийж гүйцэтгэх.
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	Ажлын зураг төсөв хоёр үе шаттай: - Эх загвар зураг боловсруулж, батлуулах; - Ажлын зураг төсөв боловсруулж, зөвшилцөж, батлуулах Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
8	Зураг төслийн байгууллага	Барилга хот байгуулалтын сайдын тушаалаар батлагдсан "Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт засвар, үйлчилгээ, эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам"-ын Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий хуулийн этгээд:
9	Төслийн захиалагч	Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар Нийслэлийн Боловсролын газар
10	Онцгой нөхцөл	<u>Газар</u> Газар чөлөөлөлттэй. Одоогоор 2270 м2 талбай дээр Нийслэлийн Засаг даргын захирамж гарсан бөгөөд эргэн тойрны айл өрхтэй зөвшилцөн бичиг баримтын зөрчлийг арилгуулж байгаа тул газрын хэмжээ нэмэгдэнэ. <u>Барилга байгууламж:</u> - Газар хөдлөлийн тэсвэршилийг тухайн байршилд хийгдсэн инженер геологийн дүгнэлтийг үндэслэнэ. - Сургалтын танхимд нарны гэрэл шууд тусахаар төлөвлөх - Барилга, өрөө тасалгаа, танхимуудын онцлогийг архитектур орон зайн өвөрмөц шийдэлтэй байхаар тусгах; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц, пандусыг норм дүрмийн дагуу төлөвлөх - Ариун цэврийн өрөөнүүдэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан 1 суултуур төлөвлөх - Спорт зал, гал тогоо, хөгжмийн танхим, эмчийн өрөөнөөс шууд гадагш гарах гарц төлөвлөнө - Спорт залын тоо 2 байхаар төлөвлөх - Гадна фасадад өнгөлгөөний тоосгоор төлөвлөх - Өнгөлгөөний тоосгыг агаарын үетэй өрөх тухай зурагт тусгах <u>Гадна талбай:</u> - Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг саадгүй түргэн аврагдах нөхцөлийг бүрдүүлэх - Авто замын зорчих хэсэг, тээврийн хэрэгслийн зогсоол, тэмдэг тэмдэглэгээг стандартын дагуу хийж гүйцэтгэх - Төв авто замд явган гарц, хурд сааруулагч төлөвлөх - Барилгын орц гарцыг гадна авто замтай болон явган замын хөдөлгөөнтэй уялдуулан төлөвлөх - Борооны ус зайлуулах байгууламжийг өндөржилттэй уялдуулан норм дүрмийн дагуу төлөвлөх - Ногоон байгууламж ба амрах талбай төлөвлөн, зам талбайд гэрэлтүүлэг хийж гадна талбайн тохижилтыг норм дүрмийн дагуу төлөвлөх - Зүлэг услах кран төлөвлөх - Цэвэр усны гадна худагт галын гидрант төлөвлөх <u>Инженерийн шугам сүлжээ:</u> - Эдэлбэр газарт газрын зураглалын тодруулалт хийлгэх, газар доорхи болон дээрх шугам сүлжээг тодруулсны үндсэн дээр зураг төслийг боловсруулах

		<ul style="list-style-type: none"> - Инженерийн шугам, сүлжээний техникийн нөхцөлийн дагуу авто зам, нийтийн эзэмшлийн зам талбайг дайрч байгаа тохиолдолд зөөх, шилжүүлэх, буулгалт болон нөхөн сэргээлтийн ажлыг зураг төсөвт тусгах - Цэвэрлэгээ үйлчилгээний зориулалттай тосгуур төлөвлөх - Агааржуулалт, салхивчийн нэгдсэн системийг норм нормативын дагуу төлөвлөх - Анги бүрийн хаалганы дотор талд цэнэг хураангууртай ослын гэрэлтүүлэг төлөвлөх - Ослын гэрэлтүүлгийг орц гарц, коридорт төлөвлөх - Анги тус бүрт хяналтын камер төлөвлөх - Гадна хяналтын камер төлөвлөх - Мэдээлэл харилцаа, холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангахуйц төлөвлөх. - Аудио систем төлөвлөх - Жижүүрийн өрөө болон сургалтын менежерийн өрөөнүүдэд хяналтын дэлгэц төлөвлөх - Сэргээгдэх эрчим хүч ашиглах - Нөөц цахилгааны эх үүсвэртэй байх.
11	Архитектур орон зайн төлөвлөлтөнд тавигдах шаардлага	<p><u>Ерөнхий төлөвлөгөө:</u></p> <ul style="list-style-type: none"> - Сургуулийн эдэлбэр газарт зам талбайг тооцож спорт талбай болон бялдаржуулах талбайтай байхаар төлөвлөх; - Ногоон байгууламжийг норм дүрмийн дагуу төлөвлөх ба шинээр төлөвлөх ногоон байгууламжийг төлөвлөлтийн бүсээс гадна нийтийн эзэмшлийн зам талбайтай уялдуулан төлөвлөх боломжийг судлан зурагт тусгах; - Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж тайлбарт тусгах; - Авто зогсоолыг хашааны гадна төлөвлөж, онцгой тохиолдолд хашаан дотор орж барилгад үйлчлэхээр төлөвлөх ба явган замтай огтлолцохгүй байхаар зурагт тусгах; - Гадна тохижилттой уялдуулан гадна хашаа төлөвлөх - Ерөнхий төлөвлөгөөний элементийг сургуулийн барилгатай уялдуулан орчин үеийн шаардлагад нийцсэн байхаар төлөвлөх; /Барилгын гадна байх зарлалын самбар, гадна гэрэлтүүлэг, мод, зүг чиг/ <p><u>Барилга:</u></p> <ul style="list-style-type: none"> - Анги хоорондох хонгил буюу коридорт хичээлийн хэрэглэл хийх шүүгээ тавихаар төлөвлөх ба энэ нь сурагчдад зорчих зайд чөлөөтэй байхаар төлөвлөх - Давхар бүрт ундны усны цорго төлөвлөх - Нэг ангид байх хүүхдийн тоог 30-с хэтрүүлэхгүй стандартын дагуу тооцон төлөвлөж өрөөний зохион байгуулалтыг байгалийн гэрэл тусч байхаар төлөвлөн бүлгүүдийн онцлогт тохирсон шийдлийг гаргах. <p><u>Барилга, байгууламжид зайлшгүй байвал зохих өрөө тасалгаа:</u></p> <ul style="list-style-type: none"> - Бага анги, дунд анги, ахлах анги, төрөлжсөн хичээлийн кабинетууд: зургийн, химийн, физикийн, биологийн лаборатори, хэлний, мэдээлэл зүйн, хөдөлмөрийн; номын сангийн өрөө, номын фонд, соёлын танхим, дуу хөгжмийн өрөө, багш нарын өрөө, эмчийн өрөө, сэтгэл зүйчийн өрөө, хувцас солих өрөө, архив, захиргааны өрөө тасалгаанууд, - Спорт зал том, жижиг 2, урлагын зал, аж ахуйн агуулах, хүнсний агуулах, хуурай агуулах, халуун цех, хоолны танхим, шатны хонгил, жижүүрийн өрөө, өлгүүр, ажилчдын ариун цэврийн өрөө, сурагчдын ариун цэврийн өрөө (6-8 насны хүүхдэд зориулсан суултуур байх),

		<ul style="list-style-type: none"> - Техникийн өрөө, аж ахуйн ажилчдийн өрөө, цэвэрлэгээний өрөө, шүршүүрийн өрөө байна.
12	<p>Ерөнхий төлөвлөгөө, Зураг төсөл боловсруулахад ашиглах материал</p>	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль - Барилгын тухай хууль - Боловсролын тухай хууль <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/ - Барилгын геодезийн ажил /БНБД 11-08-06/ - Барилгын бүтээц ба буурийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНБД 20-01-11/ - Ачаалал ба үйлчлэл /БНБД 20-04-17/ - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02 - Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм /БНБД 21-02-02/ - Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНБД 22-01-01*/ - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01-09/ - Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/ - Барилгын дулаан хамгаалалт /БНБД 23-02-09/ - Дуу чимээ тусгаарлалт /БНБД 23-05-10/ - Олон нийт иргэний барилга /БНБД 31.03.03/ - Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-01-14/ - Усан хангамж. Гадна сүлжээ ба байгууламж /БНБД 40-02-06/ - Барилга доторх усан хангамж, ариутгах татуурга /БНБД 40-05-98/05*/ - Дотор сантехникийн ажил /БНБД 3.05.01-88/ - Усан хангамж, бохир ус, гадна шугам, түүний барилга байгууламж /БНБД 3.05.04-90/ - Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер /БНБД 41-01-11/ - Дулааны сүлжээ /БНБД 41-02-13/ - Дулааны шугам сүлжээ /БНБД 3.05.03-95/ - Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/ - Автоматжуулалтын систем /БНБД 3.05.07-90/ - Бетон ба төмөр бетон бүтээц. Ерөнхий журам /БНБД 52-01-10/ - Барилгын бүтээц, ажлын төрлөөр төсвийн суурь норм, түүний хавсралтуудыг боловсруулах хэрэглэх дүрэм /БНБД 81-10-02/ - Барилгын үнэ бүрдлийн үндсэн дүрэм /БНБД 81-94-12/ - Барилгын төсөв зохион дүрэм /БНБД 81-95-12/ - Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/; - Хот суурины гудамж, зам төлөвлөлт /БНБД 32-01-04/ - Барилгын орчны тохижилтын ажил /БНБД 3.01-06-90/ - Орчны аюулгүй байдал: Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS0001-01:2019 - Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага хэрэгцээ UCS0001-02:2019 - Гадна орчны тохижилт: Хүүхдийн тоглоомын талбайн эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага UCS0002-02:2019 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/;

		<ul style="list-style-type: none"> - Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/; - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - Барилгын төсөв зохиох дүрэм БНБД 81-95-12 - Бусад холбогдох норм, дүрэм; <p><u>Төсөл, хөтөлбөрүүд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага;
13	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм /БНБД 21.02.02/; - Барилга, байгууламжийн галын аюулгүй байдал /БНБД 21-01-02/
14	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон бусад зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцох.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН
ГАЗРЫН СХОТХ-ИЙН ДАРГА

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗЫН
ЗТХ-ИЙН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗЫН
ЗТХ-ИЙН АХЛАХ ИНЖЕНЕР

НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗЫН
ЗТХ-ИЙН ХЯНАЛТЫН ИНЖЕНЕР

..... /Ж.ЭНХТӨР/

..... /Б.ЛХАГВАЖАВ/

..... /З.НЭРМӨНХ/

..... /Э.БАЯРМАГНАЙ/

..... /Д.ТҮВШИНБИЛЭГ/